



2026-2027

Mitsubishi Asian Children's Enikki Festa

ОРОЛЦОГЧДОД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

Зохион байгуулагчид

Мицубишигийн Олон нийттэй харилцах хороо

Ази, Номхон далайн бүсийн ЮНЕСКО-гийн клуб, нийгэмлэгүүдийн холбоо (AFUCA)

ЮНЕСКО-гийн нийгэмлэгүүдийн Японы үндэсний холбоо

Үндэсний зохион байгуулагч

ЮНЕСКО-ийн батламжит ТББ - Байгаль, соёлын өвийг хамгаалах сан

Дэмжлэг үзүүлсэн

ЮНЕСКО

Япон Улсын Гадаад харилцааны яам

Япон Улсын Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам

Оролцогч улс орнууд

Бангладеш, Бутан, Бруней, Камбож, Бүгд Найрамдах Хятад Ард Улс,

Энэтхэг, Индонез, Казахстан, Бүгд Найрамдах Солонгос Улс, Лаос, Малайз, Мальдив, Монгол,

Мьянмар, Балба, Пакистан, Филиппин, Сингапур, Шри Ланка, Хятадын Тайпэй, Тайланд,

Тимор-Лесте, Вьетнам, Япон

Энэхүү арга хэмжээ нь дэлхийн хүүхдүүдэд зурагт өдрийн тэмдэглэлээр дамжуулан Азийн хүмүүсийн өдөр тутмын амьдралтай танилцаж, тэднийг илүү сайн ойлгох боломж олгох зорилготой. Бид Азийн 24 улс (үүнд нэг бүс нутаг багтана)-ын хүүхдүүдийг “Азийн хүн бүртэй хуваалцахыг хүссэн миний амьдрал” сэдвээр зурагт өдрийн тэмдэглэлээ бүтээн ирүүлэхийг урьж байна. Та ч бас гурван хуудас зурагт өдрийн тэмдэглэлээрээ өөрийн амьдрал, соёлыг Азийн найзууддаа танилцуулж, энэхүү арга хэмжээнд оролцоорой.

1. ФЕСТИВАЛИЙН ХУВААРЬ

- (1) Бүтээл хүлээн авах хугацаа: 2026 оны 7 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 30-ныг дуустал
- (2) Үндэсний шалгаруулалт: 2026 оны 12 дугаар сарын 1-31
- (3) Олон улсын шалгаруулалт: 2027 оны 4-5 дугаар сар (Япон Улс)
- (4) Шагнал гардуулах ёслол ба соёлын солилцооны хөтөлбөр: 2027 оны 7-8 дугаар сар (Токио, Япон Улс)

2. БҮТЭЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

(1) Бүтээлийн бүрдэл

Энники бүрийг **A4 хэмжээтэй [урт 297 мм × өргөн 210 мм] зургийн цаас** эсхүл түүнтэй адил хэмжээтэй цаасан дээр усан будаг, өнгийн харандаа, тосон харандаа зэрэг хэрэгслээр зурна. Оролцогчийн бүтээл **гурван (3) хуудас** байна.

“ЭННИКИ” (ЗУРАГТ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ)

Японд өдөр тутмын үйл явдал, бодол санаагаа зураг болон богино хэмжээний бичвэрээр илэрхийлсэн “Энники” (зурагт өдрийн тэмдэглэл) хөтлөх уламжлал бий. “Энники”-д зохиогч зөвхөн өөрийн үзсэн, сонссон, хийсэн болон бодсон зүйлсээ бичээд зогсохгүй, өөрийн дотоод ертөнц, мэдрэмж, сэтгэлгээний баялаг онцлогийг мөн илэрхийлдэг. Зураг нь хэл болон бичиг үсгийн ялгаанаас үл хамааран хүн бүрд ойлгогдох боломжтой тул “Энники” нь соёл хоорондын харилцан ойлголцлыг хөгжүүлэхэд нэн үр дүнтэй арга хэрэгсэл болдог.



栢原の里にある竹内神社の祭りに行きました。境内に入ると長さ13m以上の大きな幟が何本も立っています。鬼のことを呉では「ヤバ」といいます。ヤバの髪は素材は和紙でできています。稚児行列も鮮やかな衣装で美しくなっています。射的やたきさんの屋台があり毎年楽しみにしています。

2024-2025 оны фестивалийн Япон
Улсын Гран-при шагналын эзэн Саяака
Ишибашигийн Энники бүтээлээс.

(2) Сэдэв

“Энэ бол миний амьдрал”

(Өөрийн амьдралтай холбоотой хүссэн сэдвээ сонгож болно.)

Азийн найзууддаа танилцуулж, хуваалцахыг хүссэн өдөр тутмын амьдрал, бодол мэдрэмжээ “ЭННИКИ” зурагт өдрийн тэмдэглэлээр илэрхийлээрэй.

Бүтээлдээ өдөр тутмын амьдрал, өөрт тохиолдсон үйл явдал, байгаль, цаг агаар, дуртай тоглоом, гэр бүл, найз нөхөд, сургуулийн амьдрал, нутгийн баяр наадам, ёс заншил, уламжлалт урлаг, соёлын арга хэмжээ зэрэг хүссэн зүйлээ чөлөөтэй дүрслэн харуулж болно.

(3) Насны ангилал

6-12 насны хүүхдүүд оролцоно. Бүтээлээ ирүүлэх үед 6-12 настай байна.

(4) Бүтээл хүлээн авах хугацаа

Үндсэн хугацаа: 2026 оны 7 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 30-ныг дуустал.


Гэхдээ тухайн улс, бүс нутгийн хичээлийн жилийн хуваарь зэрэг нөхцөлд тулгуурлан Гүйцэтгэх хороо бүтээл хүлээн авах хугацааг эцэслэн тогтооно.

(5) Хэлбэр, хэмжээ

A4 хэмжээтэй (урт 297 мм × өргөн 210 мм) цаасны дээд хэсгийн гуравны хоёрт зураг зурж, доод хэсгийн гуравны нэгт эссэгээ бичнэ.

Зураг болон эссэг цаасны зөвхөн нүүрэн талд байрлуулна.

Цаасны ар талыг ашиглахгүй.



(6) Бүтээл ирүүлэх журам

а) Гурван хуудас бүрийн ар талд оролцогчийн нэрийг бичиж, хуудсуудыг 1-ээс 3 хүртэл дарааллаар дугаарласан эсэхийг нягтална. Оролцогч өөрөө бөглөсөн бүртгэлийн маягтыг гурван хуудас Энники бүтээлийн хамт дугтуйнд хийж Үндэсний зохион байгуулагч байгууллагад илгээнэ.

б) Бүтээлийг цавуудах, үдээсний машинаар үдэх, ламинатлах зэргээр гэмтээж болохгүй.

(7) Бүтээлд тавих шалгуур

- 1) Оролцогчийн бүтээл зөвхөн өөрийнх нь бие даасан эх бүтээл байх бөгөөд өмнө нь аливаа хэлбэрээр нийтэд дэлгэгдэж, хэвлэгдэж байгаагүй байна. Бусдын зохиогчийн эрхийг зөрчиж болзошгүй эсхүл Энники бүтээлийн анхдагч, бие даасан байдлыг үгүйсгэх дараах зүйлс агуулсан бүтээлийг шалгаруулалтаас хасагдаж хүчингүйд тооцогдоно:
 - а) зураг, хүүхэлдэйн зураг, бичвэр зэргийг хуулбарласан буюу дахин бүтээсэн хэсэг;
 - б) барааны тэмдэг болон/эсхүл хүний дүр төрх ашиглах эрхийг зөрчиж болзошгүй аливаа хуулбар;
 - в) сонин, сэтгүүл, зар сурталчилгаа зэрэг хэвлэмэл материалаас авсан аливаа хуулбар.
- 2) Бүтээлийг оролцогч өөрөө бүтээсэн байна. Өөрөөр хэлбэл, оролцогч зургаа өөрөө зурж, будаж, эссэгээ **өөрийн гараар бичнэ**. Дижитал аргаар бүтээсэн зураг, бичгийн машин эсхүл компьютерээр шивсэн эссэ бүхий бүтээлийг шалгаруулалтаас хасна.

(8) Шагналууд

[1] Гран-при шагнал (улс бүрээс нэг ялагч)

Ялагчид цом, дурсгалын медаль хүртэж, Япон Улсад зохион байгуулах шагнал гардуулах ёслол болон соёлын солилцооны хөтөлбөрт уригдана. (Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсвэл зохион байгуулагчдын дангаар гаргасан шийдвэрээр аяллыг цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд оролцох байсан ялагчдад дурсгалын зүйл гардуулна.)

[2] Зохион байгуулагчдын шагналууд

Мицубишигийн Олон нийттэй харилцах хорооны шагнал (улс бүрээс нэг ялагч)

Ялагчид шагналын гэрчилгээ, дурсгалын бэлэг гардуулна.

Ази, Номхон далайн бүсийн ЮНЕСКО-гийн клуб, нийгэмлэгүүдийн холбооны шагнал

(улс бүрээс нэг ялагч)

Ялагчид шагналын гэрчилгээ, дурсгалын бэлэг гардуулна.

ЮНЕСКО-гийн нийгэмлэгүүдийн Японы үндэсний холбооны шагнал

(улс бүрээс нэг ялагч)

Ялагчид шагналын гэрчилгээ, дурсгалын бэлэг гардуулна.

(9) Шалгаруулах журам

Улс тус бүрийн Гүйцэтгэх хороо эхний шатны шалгаруулалтыг зохион байгуулж, дөрвөн бүтээлийг сонгоно. Сонгогдсон дөрвөн бүтээлийг Япон Улс руу илгээж, тэнд Олон улсын шалгаруулах хороо шүүн хэлэлцсэний үндсэн дээр шагналт ЭНИККИ буюу “Зурагт өдрийн тэмдэглэл” бүтээлүүдийг тодруулна.

*Япон Улс руу илгээсэн бүтээлийг буцаан олгохгүйг анхаарна уу. Бүтээлүүдийг ашиглах эрх нь зохион байгуулагчдад хадгалагдана.

(10) Шалгаруулах үзүүлэлт

Шалгаруулах хороо бүтээлийг зөвхөн сайн эсвэл муу зурсан эсэхээр нь дүгнэхгүй. Харин оролцогч өөрийн соёл, өдөр тутмын амьдрал, сэтгэгдэл, бодол санааг хэрхэн дүрслэн илэрхийлснийг харгалзан үзнэ.

Шалгуур үзүүлэлтүүд:

- [1] ЭНИККИ нь улс, бүс нутгийн соёл, үндэсний онцлог, ёс заншил, ахуй амьдрал, байгаль, хүрээлэн буй орчны өвөрмөц шинжийг илэрхийлж тусгасан эсэх.
- [2] ЭНИККИ нь хүүхэд бодит мэдрэмж, үзэл бодлыг хэрхэн илэрхийлж тусгаж байгаа.
- [3] Санаа, зохиомж, гүйцэтгэл нь хэр нягт нямбай болсон эсэх.
- [4] ЭННИКИ нь өргөн хүрээтэй сэдвийг хамарсан эсэх.

АСУУХ ЗҮЙЛ БАЙВАЛ ДООРХ ХАЯГААР ХОЛБОГДОНО УУ:

БАЙГАЛЬ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ САН

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р Хороо,

Нарны Зам Гудамж, “Ривер Вилла” - 8/1, 57 тоот

Харилцах утас: 99122722; 80988094

(Email: enikkimongolia@gmail.com FB: fb.me/enikkifesta)

БҮТЭЭЛИЙГ “МОНГОЛ ШУУДАН”-ИЙН САЛБАРТ ХАНДАН ДООРХ ХАЯГААР ИЛГЭЭНЭ ҮҮ:

БАЙГАЛЬ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ САН

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р Хороо,

Нарны Зам Гудамж, “Ривер Вилла” - 8/1, 57 тоот

Харилцах утас: 99122722; 80988094

(Email: enikkimongolia@gmail.com FB: fb.me/enikkifesta)